

## ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНД ДҮГНЭЛТ ХИЙСЭН ТУХАЙ

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумдын өвөлжилтийн байдал, цаг үеийн ажилтай танилцах, шалгах, зөвлөн туслах ажлаар 1 дүгээр сард 7 хэсэг тус бүрийн чиглэлд 3-7 хоног ажиллав.

Ажлын хэсгүүд ажиллах хугацаандаа журамд заасны дагуу иргэдээс, төрийн үйлчилгээг хэрхэн үнэлж байгаа талаар сэтгэл ханамжийн судалгааг авлаа. Хөдөөгийн хүн амаас 2560, Мөрөн сумын хүн амаас 700 нийтдээ 3260 иргэнээс судалгаа авав.

Төрийн үйлчилгээ үзүүлдэг төсөвт албан газрууд болон Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжилт, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар 7-10 асуултаар тус бүр хангалттай, дунд зэрэг, хангалтгүй гэсэн үнэлгээгээр авахад аймгийн дүнгээр хангалттай гэсэн үнэлгээ өгсөн иргэд 35,2%, дунд зэрэг-43,9%, хангалтгүй -20,9%-тай байв.

Эндээс дунд зэрэгт харгалзаж байгаа хувийг 2-т хувааж хангалттай, хангалтгүй гэсэн 2 үзүүлэлтэнд нэмж тооцоход хангалттай үзүүлэлт нь 57,2% буюу 2,9 оноотой, хангалтгүй үзүүлэлт нь 42,9% буюу 1,05 оноотой гарч байна.

Хөдөөгийн сумын иргэдээс авсан судалгааны хангалтгүй гэсэн үнэлгээнд дүгнэлт хийж үзэхэд сумын ИТХ, ЗДТГ-ыг иргэддээ хүрч үйлчилдэггүй, хүнд суртал гаргадаг, тодорхой ажил зохион байгуулдаггүй гэжээ. Харин эмнэлэг, сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагуудад эмийн хүрэлцээ муу, ёс зүйгүй, анги, танхим, байр сууцны чанар, хүрэлцээ муу, тоног төхөөрөмжгүй, удирдлага, зохион байгуулалт муутай гэсэн үнэлэлт ихэнх хувийг эзэлж байна. Сүүлийн үед тендер авч байгаа барилгын ажил гүйцэтгэсэн компаниудын чанаргүй барилгаас болж хөдөө орон нутагт төрийн үйлчилгээ үзүүлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Энэ асуудалд шат шатандаа хяналт тавьж, мэргэжлийн байгууллагууд анхааралдаа авч, орон нутагт үүсч буй хохирлыг гүйцэтгэгч компаниудаар төлүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзэж байна.

Аймгийн төв буюу Мөрөн сумын 700 иргэнээс 10 асуултаар хэрэглэгчийн үнэлгээг авахад:

- Хангалттай- 19,87%
- Дунд зэрэг – 58,85%
- Хангалтгүй – 20,65% гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Үүнээс дунд зэрэг гэсэн үнэлгээг 2-т хувааж үзэх юм бол хангалттай 49,2% буюу 2,46 оноотой, хангалтгүй- 50,1 буюу 2,50 оноотой байна.

“Та хангалтгүй гэж үнэлсэн шалтгаанаа бичнэ үү” гэсэн асуултанд хариулсан байдлыг авч үзвэл:

1. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг та хэрхэн үнэлж байна вэ гэсэн асуултанд:

- Амлалтаа биелүүлдэггүй
- Ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна.

- Зээл тусламж, жинхэнэ эзнээ олдоггүй
- Төрийн ажлын уялдаа, холбоо муу гэх мэтээр хариулсан байна.

2. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн та хэрхэн үнэлж байна вэ гэсэн асуултанд:

- Хүндээ хүрч ажилладаггүй.
- Хийсэн ажил нь ил тод бус.
- Гарсан шийдвэр хэрэгждэггүй.

3. Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааг хэрхэн дүгнэх вэ?

- Үр дүн багатай дэмий зүйл их хийж байна.
- Ажлын байр бий болгох
- Ажлын хариуцлага сул байна, мэргэжсэн чадварлаг байх ёстой гэх мэтээр үнэлсэн байна.

Харин бусад байгууллагуудын хувьд хөдөөгийн сумдад өгсөн зарим үнэлгээтэй ижил боловч хүнд суртал гаргадаг, эмнэлгийн хувьд чирэгдэлтэй, бүр иргэдэд тэгш биш үйлчилдэг, соёлын үйлчилгээний чанар хүртээмж муу гэх мэт үнэлгээ өгсөн байна.

Үүнээс үзэхэд одоо ямар байгаа, цаашид юун дээрээ анхаарах вэ гэдэг талаар сумдын Засаг дарга нарын зөвлөлийн өргөтгөсөн хурал хийж, зохих ёсны үүргүүдийг өгсөн болно.

Энэ судалгааны дагуу авах арга хэмжээг хэрхэн шийдвэрлэж ажиллах талаар сумдын Засаг дарга нарт зөвлөгөө өгсөн ба 2009 оны ажлын үр дүнг үнэлсэн талаар, цаашид хэрхэн ажиллах асуудлаар гарын авлага бэлтгэн товхимол гарган бүх сумдад хүргүүлж байна.

Хянасан:

Аймгийн Засаг даргын тамгын  
газрын дарга

Г.Төмөрбаатар

ХШҮ хийсэн:

Төрийн захиргаа, удирдлагын  
хэлтсийн мэргэжилтэн

Х.Рагчаа

### Хэрэглэгчдийн үнэлгээ

№	Байгууллага	хангалттай	Сумын дундаж	
	Сумдын нэр		дунд зэрэг	хангалтгүй
1	Арбулаг	19.2	46.5	36.0
2	Алаг-Эрдэнэ	43.3	50.8	5.8
3	Баянзүрх	32.5	43.7	23.8
4	Бүрэнтогтох	39.2	50.0	8.2
5	Галт	33.0	48.8	18.2
6	Жаргалант	23.7	46.5	29.8
7	Их-Уул	43.0	48.0	9.3
8	Рашаант	34.3	49.7	15.8
9	Ренчинлхүмбэ	55.3	32.7	12.0
10	Тариалан	41.8	44.3	13.8
11	Тосонцэнгэл	25.5	37.7	36.5
12	Төмөрбулаг	35.3	50.0	14.7
13	Түнэл	50.7	34.7	14.7
14	Улаан-Уул	31.0	44.3	24.7
15	Хатгал /тосгон/	28.3	52.5	18.3
16	Ханх	24.3	28.3	47.3
17	Цагаан-Уул	23.8	40.7	35.5
18	Цагааннуур	41.0	37.5	21.5
19	Цагаан-Үүр	41.7	36.7	21.7
20	Цэцэрлэг	54.0	27.8	18.2
21	Чанд/Өндөр	16.7	62.7	16.0
22	Шинэ-Идэр	47.7	37.3	15.0
23	Эрдэнэбулган	32.0	43.2	24.7
24	Мөрөн	19.9	58.8	20.6
	дүн	35.2	43.9	20.9

ХШҮ хийсэн:

Төрийн захиргаа, удирдлагын  
хэлтсийн мэргэжилтэн

Х.Рагчаа

